



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

「 Нэгдсэн сургалт зохион байгуулах тухай 」

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2, 13.3.5, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны “Сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай” А/309 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд нэгдсэн аргачлал олгох сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 20,21-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Нэгдсэн аргачлал олгох сургалтын удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, оролцох бүрэлдэхүүний нэрийг гуравдугаар, шаардагдах зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Нэгдсэн сургалтад шаардагдах 262.400 (хоёр зуун жаран хоёр мянган дөрвөн зуу) төгрөгийг хичээл, үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧУЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн
01/04 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



НЭГДСЭН ДАДЛАГА СУРГАЛТЫН УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийн удирдлага, зохион байгуулалт, алба хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулах, хууль эрх зүй, цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлж, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

ХОЁР. ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Онцгой байдлын байгууллагын Сургалтын бодлого зэрэг алба хаагчдыг ажлын байранд сургаж бэлтгэх, тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд баримтлах үндсэн баримт бичгийг үндэслэн зохион байгуулна.

ГУРАВ. ДАДЛАГА СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР, ХУГАЦАА

Дадлага сургалтыг Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 74 дүгээр ангийн сургалтын танхимд 2020 оны 01 дүгээр сарын 20,21-ны өдрүүдэд зохион байгуулна.

ДӨРӨВ. ДАДЛАГА СУРГАЛТАД ХАМРАГДАХ БҮРЭЛДЭХҮҮН

Нийслэлийн Онцгой байдлын газрын Дотоод хяналт шинжилгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн алба хаагчид, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар хамрагдана.

ТАВ. ДАДЛАГА СУРГАЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дадлага, сургалтын хүрээнд алба хаагчдын хууль эрх зүй, цэргийн хэрэг, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

1. Онцгой байдлын байгууллага, Нийслэлийн Онцгой байдлын газраас 2020 онд дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангаж цэргийн албыг хэвшүүлэх, сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг сайжруулах, гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээний чиглэлээр хичээл, сургалтыг явуулж, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;

2. Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийн удирдан зохион байгуулах, илтгэх ур чадварын түвшинг алба хаагч нэг бүрээр хичээл заалгаж тодорхойлох;

3. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээг бодитой төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагаандаа шинэлэг арга барилаар, дэвшилтэд инновацыг нэвтрүүлэх талаар ярилцлага явуулах;

4. Дадлага, сургалтын үр дүнг үндэслэн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээг зохион байгуулахад иргэд олон нийтэд чиглэсэн сургалтыг удирдан зохион байгуулах арга зүйг сайжруулах чиглэлээр зөвлөмж гаргах.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн
11/04 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НЭГДСЭН ДАДЛАГА СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Зохион байгуулах хугацаа: 2020 оны 01 дүгээр сарын 20,21-ны өдрүүд

Зохион байгуулах газар: Нийслэлийн Онцгой байдлын газрын Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 74 дүгээр ангийн сургалтын танхим

2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

д/д	Хичээлийн сэдэв	Хугацаа	Үргэлжлэх хугацаа	Зохион байгуулах албан тушаалтан, хичээл заах багш
1	Бүртгэл	08:30-08:45	15 минут	ДХШҮЭУТ-ийн ахлах мэргэжилтэн Ахмад Ц.Чинзориг
	Жагсаалын үзлэг	08:45-09:00	15 минут	ДХШҮЭУТ-ийн дарга Хошууч Ж.Төмөрмандах
2	Сургалтын зорилго, хөтөлбөрийг танилцуулах	09:00-09:10	10 минут	ДХШҮЭУТ-ийн ахлах мэргэжилтэн Ахмад Ц.Чинзориг
3	Сургалтын нээлт	09:10-09:20	10 минут	НОБГ-ын дэд дарга, Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар
4	Онцгой байдлын байгууллагаас 2020 онд Гамшгийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр хийж хэрэгжүүлэх арга хэмжээ	09:20-09:40	20 минут	ОБЕГ-ын ГЭУГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Д.Базаррагчаа
5	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2020 онд нийслэлийн хэмжээнд зохион байгуулах ажил, гүйцэтгэлийн төлөвлөгөө танилцуулах	09:40-10:00	20 минут	ДХШҮЭУТ-ийн дарга Хошууч Ж.Төмөрмандах
6	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа	10:00-10:20	20 минут	НЗДТГ-ын ХБТХ-ийн мэргэжилтэн Э.Оргилцогцлох
7	"Гамшигт тэсвэртэй хотууд" төслийн хүрээнд 2020 онд хийгдэх ажлын танилцуулга, цаашдын хамтын ажиллагаа	10:20-10:40	20 минут	"Дэлхийн Зөн Монгол" ОУБ-ийн Гамшигт тэсвэртэй хотууд төслийн зохицуулагч Г.Алзахгүй.
8	Цайны завсарлага	10:40-10:50	10 минут	
9	ISO:31000 стандарт, Эрсдэлийг тодорхойлох, удирдах арга зүй	10:50-11:50	60 минут	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлага хариуцсан ахлах мэргэжилтэн доктор профессор Д.Түмэндэмбэрэл
10	Барилга байгууламжид Газар хөдлөлтийн тэсвэржилтийн	11:50-12:30	40 минут	НДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Д.Нямдорж

	үнэлгээ хийх аргачлал			
11	Эмнэлгийн байгууллагад гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх арга зүй	12:30-13:00	30 минут	ОБЕГ-ын ГЭУГ-ын мэргэжилтэн, ахлах дэслэгч Б.Амаржаргал
12	Цайны цаг	13:00-14:00	60 минут	
13	Агс Gis –ийн тухай ойлголт, Гамшгийн эрсдэлийн зураглал хийх арга зүй.	14:00-14:30	30 минут	СХДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Б.Цэцэгдэлгэр
14	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм	14:30-15:00	30 минут	ДХШҮЭУТ-ийн дарга Хошууч Ж.Төмөрмандах
15	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд Газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал	15:00-15:30	30 минут	БГДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч З.Батцэцэг
16	Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам, Орон зайн мэдээллийн санд мэдээлэл хэрхэн оруулах, анхаарах асуудлууд	15:30-16:00	30 минут	ЧДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Ч.Мөнгөнсарнай
17	Хорооны Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, цаашид анхаарах асуудлууд	16:00-16:30	30 минут	БХДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Н.Галбаатар
18	Багахангай, Налайх дүүргийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, цаашид анхаарах асуудлууд	16:30-17:00	30 минут	БЗДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Ж.Алтантуяа
19	Сонгинохайрхан, Багануур дүүргийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, цаашид анхаарах асуудлууд	17:00-17:30	30 минут	БГДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч У.Мягмарсүх
20	Хэлэлцүүлэг /Эрүүл мэнд, боловсролын салбаруудын гамшгийн эрсдэлийн үнэлгээг зохион байгуулах талаар/	17:30-17:50	20 минут	Сургалтанд оролцогчид
21	Өдрийн сургалтыг дүгнэх	17:50-18:00	10 минут	ДХШҮЭУТ-ийн мэргэжилтэн ахлах Ахмад Ц.Чинзориг

2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр

д/д	Хичээлийн сэдэв	Хугацаа	Үргэлжлэх хугацаа	Зохион байгуулах албан тушаалтан, хичээл заах багш
1	Бүртгэл	08:50-09:00	10 минут	ДХШҮЭУТ-ийн мэргэжилтэн ахлах Ахмад Ц.Чинзориг
2	Тухайн өдрийн сургалтын хөтөлбөр, алба хаагчдын хичээл заах дарааллыг танилцуулах	09:00-09:10	10 минут	ДХШҮЭУТ-ийн мэргэжилтэн ахлах Ахмад Ц.Чинзориг
3	Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн төлөвлөгөөний 2019 оны хэрэгжилт, 2020 онд хэрэгжүүлэх ажлын	09:10-09:30	20 минут	ДХШҮЭУТ-ийн мэргэжилтэн ахлах Ахмад Ц.Чинзориг

	танилцуулга.			
4	"Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030", Тогтвортой хөгжлийн зорилго, хамрах хүрээ	09:30-10:00	30 минут	НДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Д.Нямдорж
5	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын хэлэлцээрийн агуулга, зорилго, зорилтууд	10:00-10:30	30 минут	СХДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Б.Цэцэгдэлгэр
6	НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын "Аюулгүй, гамшигт тэсвэртэй хөгжих чадавхтай хотыг бий болгох" санаачилгын агуулга	10:30-11:00	30 минут	БГДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч У.Мягмарсүх
7	Цайны завсарлага	11:0-11:10	10 минут	
8	Монгол Улсын Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл	11:00-11:40	30 минут	ЧДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Ч.Мөнгөнсарнай
9	Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ	11:40-12:10	30 минут	БГДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч З.Батцэцэг
10	Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр	12:10-12:40	30 минут	БХДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Н.Галбаатар
11	Жагсаалын дүрэм	12:40-13:00	20 минут	ДХШҮЭУТ-ийн мэргэжилтэн Ахмад Ч.Батболд
12	Үдийн хоол	13:00-14:00	60 минут	
13	Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам	14:00-14:30	30 минут	БЗДОБХ-ийн мэргэжилтэн дэслэгч Ж.Алтантуяа
14	Гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээ хийх журам	14:30-15:00	30 минут	ДХШҮЭУТ-ийн ахлах мэргэжилтэн Ахмад Ц.Чинзориг
15	Хэлэлцүүлэг /Эрчим хүч, зам тээврийн салбаруудын гамшгийн эрсдэлийн үнэлгээг зохион байгуулах талаар/	15:00-16:00	60 минут	Сургалтанд оролцогчид
16	Цайны завсарлага	16:00-16:10	10 минут	
17	Дадлага сургалтын үр дүн, цаашид сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлэх арга замын талаар ярилцлага хийх	16:10-17:00	50 минут	Сургалтанд оролцогчид
18	Хаалт /НОБГ-ын удирдлагаас алба хаагчдад үүрэг өгөх/	17:00-17:20	20 минут	НОБГ-ын дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэн

Жич: Сургалтад хамрагдах алба хаагчид албаны өдөр тутмын хувцас /китель/-тай, хувийн болон хичээл заах бэлтгэлээ хангаж ирнэ.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн
А/М дугаар тушаалын гуравдугаар хавсралт



НЭГДСЭН СУРГАЛТАД ОРОЛЦОХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭР

д/д	Цол	Овог нэр	Харьяа анги,	Албан тушаал
1	Дэд хурандаа	Д.Базаррагчаа	ОБЕГ	ГЭУГ-ын ахлах мэргэжилтэн
2	Ахлах дэслэгч	Б.Амаржаргал	ОБЕГ	ГЭУГ-ын мэргэжилтэн
3	Энгийн	Э.Оргилцогцлох	НЗДТГ	ХБТХ-ийн мэргэжилтэн
4	Энгийн	Г.Алзахгүй.	"Дэлхийн Зөн Монгол" ОУБ	Гамшигт тэсвэртэй хотууд төслийн зохицуулагч
5	Доктор, профессор	Д.Түмэндэмбэрэл	МХЕГ	Эрсдэлийн удирдлага хариуцсан ахлах мэргэжилтэн
6	Дэд хурандаа	Э.Эрдэнэбаатар	НОБГ	НОБГ-ын дэд дарга, Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга
7	Хошууч	Ж.Төмөрмандах	НОБГ	ДХШҮЭУТ-ийн дарга
8	Ахмад	Ц.Чинзориг	НОБГ	ДХШҮЭУТ-ийн ахлах мэргэжилтэн
9	Ахмад	Ч.Батболд	НОБГ	ДХШҮЭУТ-ийн мэргэжилтэн
10	Дэслэгч	Д.Нямдорж	НДОБХ	ГЭУУХМэргэжилтэн
11	Дэслэгч	Б.Цэцэгдэлгэр	СХДОБХ	ГЭУУХМэргэжилтэн
12	Дэслэгч	У.Мягмарсүх	БГДОБХ	ГЭУУХМэргэжилтэн
13	Дэслэгч	Ч.Мөнгөнсарнай	ЧДОБХ	ГЭУУХМэргэжилтэн
14	Дэслэгч	З.Батцэцэг	СБДОБХ	ГЭУУХМэргэжилтэн
15	Дэслэгч	Н.Галбаатар	БХДОБХ	ГЭУУХМэргэжилтэн
16	Дэслэгч	Ж.Алтантуяа	БЗДОБХ	ГЭУУХМэргэжилтэн

--ооо--

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн
А/Одугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



НЭГДСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Нэгжийн үнэ /төгрөг/	Хамрагдах албан хаагчдын тоо	Сургалт явагдах хоног	Өдөрт	Нийт /төгрөг/
1	Кофе	350	16	2	2	22.400
2	Печень, цайны боов	1100		2	2	70.400
3	1 удаагийн аяга	150		2	2	9.600
4	Өдрийн хоол	5000		2	1	160.000
Хэсгийн дүн						262.400

--000--